



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,
Утас. 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2015.03.16. № 333
танай _____ ны № _____ т

Г НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН
ГАЗРЫН ДАРГА Б.БАТЦЭНГЭЛ
ТАНАА

Санхүүгийн тайлангийн аудитын гэрчилгээ,
аудитыг дуусгавар болгосон тухай тайланг хүргүүлж
байна.

Хавсралт хуудас

ДЭД ДАРГА

Т.САРАНТУЯА

1110400333



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Ж.Лхагвасурэнгийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.gov.mn, http://www.city.audit.mn

2015.03.16. № 334.
таний № т

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН
ГАЗРЫН ДАРГА Б.БАТЦЭНГЭЛ
ТАНАА

АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Нийслэлийн соёл, урлагийн газрын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Нийслэлийн Аудитын газраас аудит хийв.

Нийслэлийн соёл, урлагийн газрын удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Нийслэлийн Аудитын газар нь Нийслэлийн соёл, урлагийн газрын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Нийслэлийн Аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн соёл, урлагийн газрын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохицой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийслэлийн соёл, урлагийн газрын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцуулэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц. ОЧИРБАТ



1110400334



НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:

T.Сарантуяа

Нийслэлийн аудитын
газрын дэд дарга
өрөөний утас: 327744

Ц.Хосжаргал

Санхүүгийн аудитын
менежер
өрөөний утас: 315558

Ц.Саранцэцэг

Ахлах аудитор
өрөөний утас: 325093

Аудитын тайлан

Агуулга

Хавсралт 1: Менежментийн захидал

Хавсралт 2: Байгууллагаас ирүүлсэн хариу

Хавсралт 3: Аудитлагдсан санхүүгийн тайлан

Хавсралт 4: Аудитлагдсан төсвийн гүйцэтгэлийн

тайлан

ТАБЫН ХАЯГ: Нийслэлийн
аудитын газар

Байршил: Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг,
Ж.Лхагвасүрэнгийн гудамж,
Нийслэлийн засаг
захиргааны V байр

E mail: ub@audit.mn

Вэб: www.city.audit.mn

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, ўйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Аудитын гэрчилгээний тохиорох загварын талаарх дүгнэлт

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2014 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1, 18.2-д заасан Нийслэлийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн соёл, урлагийн газрын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /НАГ-АХ/2015/-СА-II-3-38/ аудит хийлгээ.

Аудитыг Төсвийн, Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Соёлын тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Нийслэлийн соёл, урлагийн газрын 2014 оны санхүүгийн тайлант Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн Сангийн яамнаас гаргасан заавар, журам, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Нийслэлийн соёл, урлагийн газрын 2014 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 1 дүгээр сарын 25-наас 2015 оны 3 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Нийслэлийн аудитын газрын санхүүгийн аудитын II албаны III багийн ахлах аудитор Ц.Саранцэцэг 2015 оны 3 дугаар сарын 12-ны хооронд хийж гүйцэтгэв.

Нийслэлийн соёл, урлагийн газар 2014 оны санхүүгийн тайлант 2015 оны 1 дүгээр сарын 25-нд Нийслэлийн аудитын газарт ирүүлэв.

2015 оны 3 дугаар сарын 16-ны 334 тоот гэрчилгээ, аудитын тайлант Нийслэлийн соёл, урлагийн газрын удирдлагад хүргүүлэв.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Нийслэлийн соёл, урлагийн газрын төсвийн захирагч нь Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Соёлын тухай хууль болон холбогдох тогтоол, шийдвэр, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуулинд өөрчлөлт ороогүй байна.

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2014 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Байгууллагын зорилго, уйл ажиллагаа

Соёлын тухай хуулийн 3. "соёлын байгууллага" гэдэгт энэ хуулийн дагуу соёлын үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нээж хамаарна", 1. "соёлын үйл ажиллагаа" гэдэгт соёлын үнэт зүйлийг бутээх, эзэмших, ашиглах, хадгалж хамгаалах, судлах, түгээн дэлгэрүүлэхтэй холбоотой дараах үйл ажиллагаа хамаарна:" гэж энэ байгууллагын чиг үүргийг тодорхойлсон байна.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16.1 "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна", 16.4.18."төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна." гэж заасны дагуу Нийслэлийн соёл, урлагийн газрын дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Нийслэлийн соёл, урлагийн газрын 2014 оны төсвийг Нийслэлийн төрийн сангаас олгож байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой зарим хууль, журам, зааврын хэрэгжилт зарим талаараа хангалтгүй байна.

Нийслэлийн соёл, урлагийн газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

**Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим,
хяналтын сорил болон нарийвчилсан горим , түүний үр дүн**

Аудит хийхэд Нягтлан бodoх бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Нийслэлийн соёл, урлагийн газрын 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансадад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын, нарийвчилсан горим, сорил 5-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бodoх бүртгэлийн бодлого, системтэй танилцахад нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөн ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн. Уг бодлогын баримт бичигтэй бүртгэлийн програм уялдсан байна

**НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2014 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Нийслэлийн соёл, урлагийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Нийслэлийн соёл, урлагийн газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайлланг гарасан байна.

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайландаа материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нийслэлийн соёл, урлагийн газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хангалттай байна.

**Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл,
туүний талаарх тайлбар**

2014 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу нийслэлийн төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжилснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Нийслэлийн соёл, урлагийн газрын төсвийн захирагч нь 2014 онд Нийслэлийн төсвөөс урсгал зардалд 188,735.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд Соёл, урлагийн сангаас 35,000.0 мянган төгрөг, Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 434,722.6 мянган төгрөг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 1800,0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагаанаас 11,370.0 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагаанаас 172.9 мянган төгрөг, урьд оны төсвийн хэмнэлтээс 12,812.2 мянган төгрөг нийт 684,612.7 мянган төгрөгийн орлого орсон байна. Урсгал зардалд 188,735.0 мянган төгрөг батлагдсанаас 185,343.8 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвөөс 3,391.2 мянган төгрөг дутуу зарцуулсан байна. Санхүүжилтийн үлдэгдэл 3,391.2 мянган төгрөг, оны эхний үлдэгдэл 196.8 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн данснаас 134.2 мянган төгрөг, нийт 3,722.2 мянган төгрөгийг Нийслэлийн төрийн санд төвлөрүүлсэн байна.

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2014 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс хийгдсэн санхүүжилтийн
зарцуулалт

№	Нийслэлийн Засаг даргын захирамжийн оноо, дугаар	Арга хэмжээний нэр	Дүн, мянган төгрөг
1	2014 A/520	Нийслэлийн 375 жилийн ойн арга хэмжээ	201,715.6
2	2014 A/532	Халх голын ялалтын 75 жилийн ойн арга хэмжээ /Зайсан толгойн засвар/	49,348.0
3	2014 A/376	Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээ	133,459.0
4	2014 A/766	“Их талын жааз” олон улсын фестиваль	20,000.0
5	2014 A/846	“Нээлттэй Улаанбаатар – 2014” олон улсын форум	6,000.0
6	2014 A/787	Хүүхдийн найрал дууны уралдаант наадам	24,200.0
Дүн			434,722.6

Шилэн дансны мэдээлэл

Байгууллагын цахим хуудсанд шилэн дансны цэс үүсгэж, 2015 оны батлагдсан төсвийн хуваарь, 2015 оны 1, 2 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг байршуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний ур дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 3 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 5 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Дансны бичилт буруу хийсэн зөрчил нь санхүүгийн тайлангийн толилуулга ба илчлэл гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн тодруулгууд буруу илэрхийлэгдэхэд хүргэсэн байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх
(тохиromжтой бол) тайлбар

Нийслэлийн соёл, урлагийн газрын 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлэхүйц хэмжээний 404,037.5 мянган төгрөгийн буюу нийт ажил гүйлгээ, үлдэгдлийн 59.0 %-ийг нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. Дансны бичилтийн зөв хийгдсэн эсэхийг 100.0% шалгасан. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар

**НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2014 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Өглөгийн дансаар дамжуулалгүй, 1,611.6 мянган төгрөгийн гүйлгээг зардалд шууд тусгасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 3.10 дахь заалттай нийцэхгүй байна. Мөн байгууллагаас зохион байгуулсан соёл, урлагийн арга хэмжээний зардлын тооцоог мөнгөн урьдчилгааны дансанд бүртгээгүй, зардалд шууд тусгасан байна.

- **Шийдвэрлэсэн нь:** Цаашид ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулан бүртгэж байх, мөнгөн урьдчилгааны тайланг хариуцсан ажилтнуудаар гаргуулж, хэвшиг зөвлөмж өгсөнийг хүлээн зөвшөөрсөн хариу ирүүлсэн.

2. Бараа материалын тайланд тусгаагүй, жолоочийн замын хуудас хөтлөөгүй 453.6 мянган төгрөгийн шатахууныг зардалд шууд тусгасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.21 заалттай нийцэхгүй байна.

- **Шийдвэрлэсэн нь:** Цаашид бараа материалын тайлангаар дамжуулж зарцуулалт хийх, жолоочийн замын хуудсыг хөтөлж байх зөвлөмж өгсөнийг хүлээн зөвшөөрсөн хариу ирүүлсэн.

3. Цалин хөлс, тээврийн хөлсний үүссэн тооцоог тухай бүрд нь журналд бичилгүй, улирлын эцэст бөөн дүнгээр тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2. “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх” заалтыг зөрчсөн байна.

- **Шийдвэрлэсэн нь:** Гарсан ажил гүйлгээг тухай бүрд нь бүртгэж байх зөвлөмж өгсөнийг нь хүлээн зөвшөөрсөн хариу ирүүлсэн.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Хууль журам зөрчсөн 2,065.2 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулаагүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд байхгүй.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Нийслэлийн соёл, урлагийн газрын 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,065.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2014 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн захирагчийн төсвийн 2013 оны санхүүгийн тайланд НАГ-ын хийсэн аудитаар 1 зөвлөмж өгсөн, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласнаар 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд зөрчил давтан гараагүй байна.


Зөрчилгүй санал дүгнэлт

Нийслэлийн соёл, урлагийн газрын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 9 хуудас, менежментийн захидал 4 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДЭД ДАРГА  Т.САРАНТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР  Ц.ХОСЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  Ц.САРАНЦЭЦЭГ

2014.03.17

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН
ГАЗРЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН



Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс:

Асуудал 1	
Зардал.....	3
Асуудал 2	
Бараа материал	3
Асуудал 3	
Өглөг.....	4

2015 оны 3 дугаар сар 11

Менежментийн захидал

Нийслэлийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Нийслэлийн соёл, урлагийн газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Нийслэлийн аудитын газар та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Нийслэлийн соёл, урлагийн газрын санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Зардал

Тэргүүлэх ач холбогдол №3

НАГ-ЫН АЖИГЛАЛТ

Өглөгийн дансаар дамжуулалгүй, 1,611.6 мянган төгрөгийн гүйлгээг зардалд шууд тусгасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 3.10 дахь заалттай нийцэхгүй байна. Мөн байгууллагаас зохион байгуулсан соёл, урлагийн арга хэмжээний зардлын тооцоог мөнгөн урьдчилгааны дансанд бүртгээгүй, зардалд шууд тусгасан байна.

НАГ-ЫН ЗӨВЛӨМЖ

Цаашид ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулан бүртгэж байх

Мөнгөн урьдчилгааны тайланг хариуцсан ажилтнуудаар гаргуулж, хэвших.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд авлага, өглөг дутуу тусгагдах, мөнгөн хөрөнгө шамшигдах

ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН ХАРИУ

Зөрчлийг хүлээн зөвшөөрч цаашид зөвлөмжийн дагуу ажиллах тухай албан хариу ирүүлэв.

Асуудал 2: Бараа материал

Тэргүүлэх ач холбогдол №3

НАГ-ЫН АЖИГЛАЛТ

Бараа материалын тайланд тусгаагүй, жолоочийн замын хуудас хөтлөөгүй 453.6 мянган төгрөгийн шатахууныг зардалд шууд тусгасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.21 заалттай нийцэхгүй байна.

НАГ-ЫН ЗӨВЛӨМЖ

Цаашид бараа материалын тайлангаар дамжуулж зарцуулалт хийх, жолоочийн замын хуудсыг хөтөлж байх

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн тодруулга буруу илэрхийлэгдэх, шатахууны зардал хэтрэх

ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН ХАРИУ

Зөрчлийг хүлээн зөвшөөрч цаашид зөвлөмжийн дагуу ажиллах тухай албан хариу ирүүлэв.

Асуудал 3: Өглөг

Тэргүүлэх ач холбогдол №3

НАГ-ЫН АЖИГЛАЛТ

НАГ-ЫН ЗӨВЛӨМЖ

Цалин хөлс, тээврийн хөлсний Гарсан ажил гүйлгээг тухай бүрд нь
үүссэн тооцоог тухай бүрд нь журнаалд бүртгэж байх.
бичилт хийлгүй, улирлын эцест бөөн
дүнгээр тусгасан нь Нягтлан бодох
бүртгэлийн тухай хуулийн 4.1.2.
санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт
материал, бодит тоо, мэдээнд
үндэслэх" заалтыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Тухайн гүйлгээ гарсан хугацаа буруу
илэрхийлэгдэх

Төсвийн захирагчийн хариу

Зөрчлийг хүлээн зөвшөөрч цаашид
зөвлөмжийн дагуу ажиллах тухай албан
хариу ирүүлэв.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ДЭД ДАРГА
АУДИТЫН МЕНЕЖЕР

Т.САРАНТУЯА
Ц.ХОСЖАРГАЛ

2015.03.11
2015.03.11

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Ц.САРАНЦЭЦЭГ

2015.03.11

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2014 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Байгууллагаас ирүүлсэн хариу



Т.Саралтнуур
Д.Оюун
13/III

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу-1, А.Амарын гудамж, Утас: 32-15-29,
Факс: (976-11) 32-45-37, <http://www.acoc.mn>


2015.03.13 № 01/96
танаи 2015.03.12-ны № 261 -т

НИЙСЛЭЛИЙН АУДИТИЙН ГАЗРЫН
ДАРГА Ц.ОЧИРБАТ ТАНАА

Тус газрын ўйл ажиллагааны 2014 оны жилийн
эцсийн санхүүгийн тайланийн байдал, илэрсэн
зөрчлийн тухай бичигдсэн менежментийн захидалтай
танилцаа.

Удирдлагын зүгээс менежментийн захидалд
дурдсан зөрчлийг хүлээн зөвшөөрч байна.

Зөвлөмжийн дагуу зөрчлийг арилгахад анхаарч
ажиллах болно.



114050009132

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2014 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	39,920,412.00	39,390,262.00
МӨНГӨН ХӨРӨНГӨ	196,750.00	-
Банкинд байгаа бэлэн мөнгө	196,750.00	-
Улсын төсвийн харилцах	196,750.00	-
БАРАА МАТЕРИАЛ	39,723,662.00	39,390,262.00
Түүхий эд материал	29,901,900.00	29,901,900.00
Тусгай зориулалттай материал	29,901,900.00	29,901,900.00
Хангамжийн материал	9,821,762.00	9,488,362.00
Бичиг хэргийн материал	-	400,900.00
Аж ахуйн материал	9,371,762.00	9,087,462.00
Түлш, шатах тослох материал	450,000.00	-
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	39,920,412.00	39,390,262.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	46,770,301.74	32,155,644.95
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	46,770,301.74	32,155,644.95
Биет хөрөнгө	46,770,301.74	32,155,644.95
Барилга, байгууламж, орон сууц	16,800,000.00	15,000,000.00
Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	24,000,000.00	24,000,000.00
Барилга, байгууламж орон сууц - Хуримтлагдсан элэгдэл	(7,200,000.00)	(9,000,000.00)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	13,129,227.36	2,242,608.35
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	230,427,304.20	230,427,304.20
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(217,298,076.84)	(228,184,695.85)
Тавилга, аж ахуйн эд хогшил	16,841,074.38	14,913,036.60
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	29,512,389.00	29,512,389.00
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(12,671,314.62)	(14,599,352.40)
Програм хангамж - Анхны өртөг	150,000.00	150,000.00
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(150,000.00)	(150,000.00)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	46,770,301.74	32,155,644.95
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	86,690,713.74	71,545,906.95
НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧ	-	-
Засгийн газрын сан	261,759,011.80	261,759,011.80
Хуримтлагдсан үр дүн	(175,720,692.62)	(190,865,499.41)
Өмнөх үеийн үр дүн	(175,720,692.62)	(175,720,692.62)
Тайлант үеийн үр дүн	-	(15,144,806.79)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	652,394.56	652,394.56
ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	86,690,713.74	71,545,906.95
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	86,690,713.74	71,545,906.95

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2014 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	422,401,100.00	660,257,600.00
Засгийн газрын бусад түвшнээс авах тусlamж санхүүжилт	422,401,100.00	660,257,600.00
Улсын төвлөрсөн төсвөөс	202,997,100.00	188,735,000.00
Ургал үйл ажиллагааны санхүүжилт	202,997,100.00	188,735,000.00
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжилт	219,404,000.00	471,522,600.00
Засгийн газрын нөөц хөрөнгө	219,404,000.00	436,522,600.00
Төсвийн хуваарилаагүй зардал	-	35,000,000.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,412,000.00	24,355,075.00
Бараа, үйлчилгээний борлуулалт	19,412,000.00	24,355,075.00
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	19,412,000.00	24,355,075.00
Үндсэн үйл ажиллагааны орлого	1,402,000.00	11,370,000.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	18,010,000.00	172,875.00
Үрьд оны төсвийн хэмнэлтийн орлого	-	12,812,200.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	441,813,100.00	684,612,675.00
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	129,017,639.00	130,597,965.00
Үндсэн болон нэмэгдэл цалин	116,354,075.00	120,024,416.00
Үндсэн цалин	116,354,075.00	120,024,416.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	12,663,564.00	10,573,549.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	11,640,988.00	8,824,350.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	11,640,988.00	7,075,150.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	-	700,000.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	-	874,600.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	-	174,600.00
Эруул мэндийн даатгалын хураамж	1,022,576.00	1,749,199.00
ҮРСГАЛ ЗАРДАЛ	304,498,898.28	560,926,270.79
Бараа үйлчилгээний ургал зардал	36,122,348.28	34,140,920.79
Бусад бараа үйлчилгээний зардал	36,122,348.28	34,140,920.79
Бичиг хэргийн зардал	3,247,350.00	1,314,300.00
Тээвэр, шатахуун	6,730,000.00	6,837,997.00
Шуудан, харилцаа холбоо	3,820,971.00	2,835,172.00
Дотоод албан томилолт	510,000.00	345,000.00
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	500,000.00	-
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	823,350.00	417,500.00
Сургалт семинарын зардал	3,410,000.00	2,490,000.00
Жижиг эд хогшил худалдан авах	-	192,500.00

**НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2014 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	-	192,500.00
Төлбөр хураамж, жижиг татварууд	1,327,300.00	1,247,495.00
Ургал засвар	5,256,500.00	3,846,300.00
Холбооны шугам ашигласны зардал	12,600.00	-
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,484,277.28	14,614,656.79
Хөтөлбөр арга хэмжээний зардал	268,376,550.00	526,785,350.00
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	253,376,550.00	526,785,350.00
Соёл урлаг хөгжүүлэх зардал	220,024,000.00	485,322,650.00
Уран бүтээлийн зардал	33,352,550.00	28,650,500.00
Үрьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт	-	12,812,200.00
Төсвийн хуваарилагдаагүй зардал	15,000,000.00	-
Бусад төсөл арга хэмжээ	15,000,000.00	-
ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГА, НЭГЖҮҮДЭД ОЛГОСОН	123,483.00	3,722,233.00
Төсвийн ерөнхийлөн захирагчидад олгосон санхүүжилт, шилжүүлэг	123,483.00	3,722,233.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	123,483.00	3,722,233.00
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ	4,672,600.00	4,511,013.00
Ажил олгогчоos өгөх бусад тэтгэмж	4,672,600.00	4,511,013.00
Мөнгөн хэлбэрээр	4,672,600.00	4,511,013.00
Нэг удаагийн тэтгэмж	4,372,600.00	4,511,013.00
Бусад	300,000.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	438,312,620.28	699,757,481.79
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	3,500,479.72	(15,144,806.79)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	3,500,479.72	(15,144,806.79)

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Өмнөх он	Тайлант он
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	422,401,100.00	660,257,600.00
Засгийн газрын бусад түвшнээс авах тусlamж санхүүжилт	422,401,100.00	660,257,600.00
Улсын төвлөрсөн төсвөөс	202,997,100.00	223,735,000.00
Ургал үйл ажиллагааны санхүүжилт	202,997,100.00	188,735,000.00
Төсвийн хуваарилаагүй зардал	-	35,000,000.00
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжилэг	219,404,000.00	436,522,600.00
Засгийн газрын нөөц хөрөнгө	219,404,000.00	436,522,600.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,412,000.00	24,355,075.00
Бараа, үйлчилгээний борлуулалт	19,412,000.00	24,355,075.00
Төсвийт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	19,412,000.00	24,355,075.00
Үндсэн үйл ажиллагааны орлого	1,402,000.00	11,370,000.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	18,010,000.00	172,875.00

**НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2014 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	-	12,812,200.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	441,813,100.00	684,612,675.00
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	129,017,639.00	131,227,965.00
Үндсэн болон нэмэгдэл цалин	116,143,055.00	118,222,465.00
Үндсэн цалин	96,518,755.00	118,222,465.00
Бусад нэмэгдлүүд	19,624,300.00	-
Үр дүнгийн урамшуулал	5,790,700.00	-
Унаа, болон бусад нөхөн олговор	13,833,600.00	-
Нийгмийн хамгааллын шимтгэл	12,874,584.00	13,005,500.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	10,532,384.00	10,659,900.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	8,188,884.00	8,314,200.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	585,900.00	938,300.00
YOMШ өвчний даатгалын шимтгэл	1,171,700.00	1,172,800.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	585,900.00	234,600.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,342,200.00	2,345,600.00
УРСГАЛ ЗАРДАЛ	294,124,783.00	545,308,214.00
Бараа үйлчилгээний урсгал зардал	26,317,383.00	20,799,814.00
Бусад бараа үйлчилгээний зардал	26,317,383.00	20,799,814.00
Бичиг хэргийн зардал	1,799,844.00	1,663,200.00
Тээвэр, шатахуун	7,200,000.00	7,037,997.00
Шуудан, харилцаа холбоо	3,998,471.00	2,407,172.00
Дотоод албан томилолт	466,000.00	345,000.00
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	500,000.00	-
Сургалт семинарын зардал	3,999,950.00	3,044,150.00
Жижиг эд хогшил худалдан авах	1,129,068.00	192,500.00
Багаж хэрэгсэл худалдан авах	195,490.00	-
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	933,578.00	192,500.00
Төлбөр хураамж, жижиг татварууд	1,414,050.00	1,247,495.00
Урсгал засвар	5,000,000.00	4,862,300.00
Холбооны шугам ашигласны зардал	810,000.00	-
Хөтөлбөр арга хэмжээний зардал	267,807,400.00	524,508,400.00
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	252,807,400.00	524,508,400.00
Соёл урлаг хөгжүүлэх зардал	222,809,250.00	-
Уран бутээлийн зардал	29,998,150.00	28,765,000.00
Бусад төвлөрсөн арга хэмжээ	-	482,931,200.00
Урьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт	-	12,812,200.00
Төсвийн хуваарилагдаагүй зардал	15,000,000.00	-
Бусад төсөл арга хэмжээ	15,000,000.00	-
ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГА, НЭГЖҮҮДЭД ОЛГОСОН	123,483.00	3,722,233.00
Төсвийн ерөнхийлөн захирагчидад олгосон санхүүжилт, шилжүүлэг	123,483.00	3,722,233.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	123,483.00	3,722,233.00

**НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2014 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ	4,684,600.00	4,551,013.00
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	4,684,600.00	4,551,013.00
Мөнгөн хэлбэрээр	4,684,600.00	4,551,013.00
Нэг удаагийн тэтгэмж	4,384,600.00	4,551,013.00
Бусад	300,000.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	427,950,505.00	684,809,425.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	13,862,595.00	(196,750.00)
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	13,665,845.00	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	13,665,845.00	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(13,665,845.00)	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	196,750.00	(196,750.00)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	196,750.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	196,750.00	-

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	261,759,011.80	652,394.56	(175,720,692.62)	86,690,713.74
Тайлант үеийн үр дүн	-	-	(15,144,806.79)	(15,144,806.79)
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	261,759,011.80	652,394.56	(190,865,499.41)	71,545,906.95

АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү /+илүү, - дутуу/	Гүйцэтгэлийн хувь
I.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II+V)	188,735,000.00	185,343,792.00	-3,391,208.00	98.2
II.НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН (III+IV)	188,735,000.00	185,343,792.00	-3,391,208.00	98.2
III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	188,735,000.00	185,343,792.00	-3,391,208.00	98.2
Бараа ажил үйлчилгээний зардал	188,735,000.00	185,343,792.00	-3,391,208.00	98.2
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	130,182,900.00	31,227,965.00	1,045,065.00	24.0
Үндсэн цалин	117,281,900.00	18,222,465.00	940,565.00	15.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,901,000.00	13,005,500.00	104,500.00	100.8
Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэл	10,555,400.00	10,659,900.00	104,500.00	101.0
Тэтгэврийн даатгал	8,209,700.00	8,314,200.00	104,500.00	101.3

**НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2014 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Тэтгэмжийн даатгал	938,300.00	938,300.00	-	100.0
YOMШ өвчний даатгал	1,172,800.00	1,172,800.00	-	100.0
Ажилгүйдлын даатгал	234,600.00	234,600.00	-	100.0
Байгууллага төлөх ЭМД-ын хураамж	2,345,600.00	2,345,600.00	-	100.0
Бараа ,үйлчилгээний урсгал зардал	58,552,100.00	54,115,827.00	-4,436,273.00	92.4
Бичиг хэргийн материал	1,759,500.00	1,663,200.00	-96,300.00	94.5
Тээвэр, шатахууны зардал	7,038,000.00	7,037,997.00	-3	100.0
Шуудан холбооны зардал	3,910,000.00	2,407,172.00	-1,502,828.00	61.6
Дотоод томилолтын зардал	977,500.00	345,000.00	-632,500.00	35.3
Ном , хэвлэлийн зардал	488,700.00	-	-488,700.00	
Сургалт семинарын зардал	3,910,000.00	3,044,150.00	-865,850.00	77.9
Жижиг эд хогшил худалдан авах зардал	195,500.00	192,500.00	-3,000.00	98.5
Төлбөр, хураамж, жижиг татварууд	1,466,200.00	1,247,495.00	-218,705.00	85.1
Урсгал засварын зардал	4,887,500.00	4,862,300.00	-25,200.00	99.5
Бусад зардал	29,325,000.00	28,765,000.00	-560,000.00	98.1
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	4,594,200.00	4,551,013.00	-43,187.00	99.1
VI. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР:	188,735,000.00	185,343,792.00	-3,391,208.00	98.2
Төсвөөс санхүүжих	188,735,000.00	185,343,792.00	-3,391,208.00	98.2